

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөгүй байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний
хэрэгжилт, үр дүн”-нд хийсэн аудитын тайлан**

АУДИТЫН КОД: АГГ-2022/16-ШТА-ГА

Чойбалсан хот
2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Я.Зориг
Утас: 7058-4207, Цахим хаяг: zorigya@audit.gov.mn
Аудитор С.Энхбаатар
Утас: 7058-4207, Цахим хаяг: enkhbaatarsu@audit.gov.mn
Аудитор Ч.Удвалноров
Утас: 7058-4207, Цахим хаяг: udvalnorovch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	4
Хүснэгт, дүрслэлийн тоёог	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	6
БҮЛЭГ А. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА.....	7
A.1. Хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөж байгаа боловч ТЕЗ-аар уламжлагдаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.....	7
A.1.1. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нь орон нутгийн бодлогын баримт бичигт нийцсэн байна.....	7
A.1.2. Жагсаалтад батлагдсан 2021 оны төсөл, арга хэмжээ нь дээд шатны байгууллагын болон УИХ-ын гишүүдийн санаачилгаар батлагдсан учир орон нутгийн салбарын бодлого, ТЕЗ-ын саналд үндэслээгүй байна.....	7
A.1.3. Орон нутгийн хэрэгцээ шаардлага, санал хүсэлтийн дагуу эрэмбэлсэн төсөл, арга хэмжээ нь улсын төсөвт тусгагдаагүй байна.....	8
A.2. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх тогтолцоо үр дүнгүй байна.....	8
A.2.1 Өмнөх оноос шилжиж ирсэн ТАХ-нд барилга, байгууламжийн зураг, төслийн ажлын даалгаврыг хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэн боловсруулаагүй, төсөв зургийн дагуу батлагдаагүй зөрчлүүд байна.....	8
A.2.2 Барилга, байгууламж, засварын ажлын зураг төслийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүд боловсруулж, баталгаажуулсан байна.....	9
A.2.3. Барилгын засварын ажлын зураг төсөвт олгосон зардлыг бодит гүйцэтгэл, жишиг үнэд үндэслэсэн байна.....	9
A.2.4. Өмнөх оноос шилжиж ирсэн аймгийн Засаг даргын Тамгын газрын барилгын төсөвт 4 удаа өөрчлөлт орсон байна.....	10
A.2.5. Магадлалын ерөнхий дүгнэлтээр шинээр хэрэгжих 1 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдсэн байна.....	10
A.3.Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх бодлогын хэрэгжилтийг хангуулаагүй байна.....	11
A.3.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нь ТЕЗ-ын хөрөнгө оруулалтын эрэмбэлсэн жагсаалтад багтаагүй учир хэрэгцээ шаардлагыг үнэлэх боломжгүй байна.....	11
A.3.2. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангаж ажиллаагүй байна.....	11
A.3.3. Төсөл арга, хэмжээний санхүүжилт нь хэрэгжих боломжтой байдлаар батлагдсан байна.	
A.3.4. Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөж батлаагүй байна.....	12
БҮЛЭГ Б. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, УЛСЫН ТӨСВӨӨС ОЛГОСОН САНХҮҮЖИЛТИЙН ЗАРЦУУЛАЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА.....	13
B.1. Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулсан байна.....	13
B.1.1. Хөрөнгө оруулалтын 2,064.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ-ний эрхийг холбогдох журамд заасан хугацаанаас хоцроож шилжүүлсэн байна.....	13
B.1.2. Төсөл, арга хэмжээг тайлант онд хэрэгжих боломжтой хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.....	14
B.1.3. Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулж, батлуулсан байна.....	14
B.1.4. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй байдлаар сонгон шалгаруулсан байна.....	14
B.1.5. ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны тайланг Шилэн дансны хууль журамд заасны дагуу цахим хуудаст ил тод мэдээлээгүй байна.	14
B.2. Захиалагч гэрээний хэрэгжилтийг хангуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулаагүй байна.....	15
B.2.1. Гүйцэтгэгчид төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд дуусаагүй, дутуу гүйцэтгэсэн зөрчлүүд илэрч байна.....	17
B.2.2. Шинээр хэрэгжсэн зарим барилгын засварын ажилд зохиогч, мэргэжлийн байгууллагын хяналт хэрэгжээгүй байна.....	17
B.2.3. Хөрөнгө оруулалтаар техник, тоног төхөөрөмж бэлтгээгүй байна.....	17
B.2.4. Өмнөх онуудаас хэрэгжиж дуусаагүй орхигдсон 4,270.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга, байгууламж байна.....	19
B.2.5. Хөрөнгө оруулалтаар орон нутагт хийж гүйцэтгэсэн зураг, төслийг холбогдох хууль, барилгын норм, дүрэм, стандартын дагуу боловсруулж, 2021 онд холбогдох төсөл, арга	

хэмжээг хэрэгжүүлэхэд ашигласан байна.....	20
Б.3. Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.....	20
Б.3.1. Хяналтын тогтолцоо бүрдсэн боловч 2 барилгын засварын ажилд мэргэжлийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагатай гэрээ байгуулаагүй, үр дүнг тооцоогүй байна.....	20
Б.3.2. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь олгосон байна.	21
Б.3.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх нь шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд ТЕЗ-ийн дотоод аудит хийгдсэн байна.....	21
Б.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт тухайн жилд батлагдсан санхүүжилтийг бүрэн ашиглах зорилгоор Засгийн газраас гарсан шийдвэрийн хэрэгжилт үр дүнтэй байна.....	22
Б.4.1. Аймгийн Засаг даргын барьцаа хөрөнгийн данснаас 2021 онд санхүүжилт олгогдоогүй байна.....	22
Б.4.2. Өмнөх онуудад Засаг даргын барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хөрөнгийг төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлсэн байна.....	22
Б.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцох боломжгүй байна.....	23
Б.5.1. Ашиглалтад орсон 3 ТАХ-ний хувьд 2 нь зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаараа ажиллаж, 1 төсөл, арга хэмжээний хувьд төсөл хэрэгжих хугацаа болоогүй байна.....	23
Б.5.2. Орон нутагт 2021 онд болон он дамжин хэрэгжиж байгаа төсөвт өртөг үндэслэлгүйгээр нэмэгдсэн төсөл, арга хэмжээ байхгүй байна.....	23
Б.5.3. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.....	24
Б.5.4. Улсын төсвийн санхүүжилтээр 2021 онд эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээнд хөрөнгө оруулалт хийгдээгүй байна.....	24
Б.5.5. Хэрэгжиж дуусан төсөл, арга хэмжээний үр дүнд дэд бүтцийн салбарын хүчин чадал нэмэгдээгүй байна.....	25
Холбогдох байгууллагын санал:.....	26
ДҮГНЭЛТ:	28
САНАЛ:	29
ЗӨВЛӨМЖ:	29
ТУШААЛ:	30

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БГБХН	Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл
БД	Бүртгэлийн дугаар
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БСУГ	Боловсрол, соёл, урлагийн газар
БСШУС	Боловсрол, соёл шинжлэх ухааны сайд
БСШУЯ	Боловсрол, соёл шинжлэх ухааны яам
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ДОА	Дорнод аймаг
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТБХБС	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
НББ	Нягтлан бодох бүртгэл
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨӨЗ	Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
УЦУОШТ	Ус цаг уур, орчны шинжилгээний төв
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦУОШГ	Цаг уур, орчны шинжилгээний газар
ШТА	Шууд тайлагнах аудит
ШУТИС	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
MNS	Mongolian national standard

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Орон нутагт 2021 оны жагсаалтад батлагдсан 4 төсөл, арга хэмжээний санал	8
Хүснэгт 2	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнд барилга байгууламжийн зураг төсөл боловсруулж, баталгаажуулсан хуулийн эдгээд	9
Хүснэгт 3	Зураг, төсвийн үнийг жишиг үнэд харьцуулсан шинжилгээ	10
Хүснэгт 4	Эрх шилжин 2021 онд бүрэн ашиглалтад орсон 2 төсөл, арга хэмжээний хувьд хэрэгцээ шаардлага, хүчин чадал	11
Хүснэгт 5	Шинээр орон нутагт 2021 онд хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээ	12
Хүснэгт 6	Барилгын засварын ангилал	13
Хүснэгт 7	Гэрээний хугацаанд дуусгаагүй, ашиглалтад ороогүй ТАХ	15
Хүснэгт 8	Орхигдсон барилга, байгууламжийн судалгаа	18
Хүснэгт 9	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээний зураг, төсөл боловсруулалт, хууль, дүрмийн ашиглалт	20
Хүснэгт 10	Улсын төсвөөр орон нутагт хэрэгжсэн барилга байгууламжийн ашиглалт, данс бүртгэл	23
Хүснэгт 11	Он дамжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн өөрчлөлт /сая.төг/	24
Хүснэгт 12	Төсөл, арга хэмжээнээс бий болсон үр дүн, өгөөж	25

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	ТАХ-ний хэрэгжилт /хувиар/	15

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалаар баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн хийлээ.
Аудитын зорилт	Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Улсын Их Хуралд болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: • Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх; • Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалт үр дүнтэй байгаа эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд Дорнод аймагт 23 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас 11 төсөл, арга хэмжээний төлөвлөлт хийсэн судалгаа, шинжилгээний баримт материал, ажлын тайлан, төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд эрх бүхий байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлд үндэслэн аудитыг хийнэ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6827-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийг тус тус ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул хянан удирдаж, аудитын менежер И.Сэмжидмаа үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор Я.Зориг, аудитор С.Энхбаатар, Ч.Удвалноров нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын дэд төлөвлөгөөг 2022 оны 02 дугаар сарын 28-ны дотор батлуулж, талбарын ажлыг 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор боловсруулж, үе шатны хяналтыг хийлгэж, тайлан, холбогдох судалгааг 4 дүгээр сарын 29-ний дотор Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлээ.

БҮЛЭГ А. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөгүй байна.

А.1. Хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөж байгаа боловч ТЕЗ-аар уламжлагдаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

А.1.1. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нь орон нутгийн бодлогын баримт бичигт нийцсэн байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд Дорнод аймагт 23 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас 11 төсөл, арга хэмжээний эрх шилжиж ирсэн байна. (УЦУОШТ-ийн конторын барилгын дээврийн засварын 2 ажлыг шууд худалдан авалтаар хийхээр эрх шилжин ирсэн).

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд нь Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн нийгэм, эдийн засгийг 2021 онд хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн байх шаардлагатай бөгөөд 2021 онд хэрэгжсэн дээрх төсөл, арга хэмжээний 65.2 хувь нь боловсрол, эрүүл мэндийн салбарт, 34.8 хувь бусад салбарт хийгдэхээр чиглэгдэж төлөвлөгдсөн байна.

- Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 5 дугаар зорилгын хүрээнд 5.1.1-д “Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төсөв, санхүүг төлөвлөн хэрэгжүүлнэ.” гэж тусгасан байна.
- Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 2.3.1, 2.4.2, 6.1.1 гэсэн заалтуудтай жагсаалтад батлагдсан төсөл арга хэмжээнүүд нь нийцэж байна.
- Дорнод аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 3.8.2.1-д “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга байгууламжийн ажилд хяналт тавьж, ашиглалтад хүлээн авах ажлыг зохион байгуулна.”

А.1.2. Жагсаалтад батлагдсан 2021 оны төсөл, арга хэмжээ нь дээд шатны байгууллагын болон УИХ-ын гишүүдийн санаачилгаар батлагдсан учир орон нутгийн салбарын бодлого, ТЕЗ-ын саналд үндэслээгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.3¹ дахь заалтын дагуу захиалагчдын саналд үндэслэсэн байх шаардлагатай.

¹ энэ журамд зааснаар үнэлж, эрэмбэлсний дагуу тухайн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг улсын төсөвт тусгуулахаар Сангийн яаманд хүргүүлэх;

Хүснэгт 1. “Орон нутагт 2021 оны жагсаалтад батлагдсан 4 төсөл, арга хэмжээний санал”

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний санал
Төсвийн тухай хуульд 2021 онд батлагдсан төсөл, арга хэмжээ		
1	Босоо тэнхлэг ба шинэ хотхоны авто зам /Дорнод, Хэрлэн сум/	Уг төсөл, арга хэмжээний санал нь УИХ-ын Х.Болорчулуун гишүүний санаачилгаар улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан байна.
Салбарын сайдын их засварын багцад багтсан төсөл, арга хэмжээ		
1	Цэцэрлэгийн барилгын худгийн насос, шугам сүлжээний засвар /Дорнод, Хэрлэн сум, 12 дугаар цэцэрлэг/	Боловсрол соёл, урлагийн газарт хүргүүлсэн хүсэлтийн дагуу БСШУЯ-нд уламжлагдаж, УИХ-ын гишүүн Х.Болорчулуун дэмжлэгтэйгээр БСШУ-ны сайдын багцад батлагдан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан байна.
2	УЦУОШТ-ийн конторын барилгын дээврийн засвар /Дорнод, Хэрлэн сум/	Аймгийн УЦУОШТ-өөс ЦУОШГ-т хүргүүлсэн хүсэлтийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан байна.
3	УЦУОШТ-ийн конторын барилгын дээврийн засвар /Дорнод, Баян-Уул/	УЦУОШТ-өөс 2019 оны 3 дугаарын 06-ны өдрийн 42 тоот албан бичгээр УИХ-ын гишүүн Н.Номтойбаярт хүсэлт хүргүүлсэн. Мөн ЦУОШГ-ын дарга, аймгийн УЦУОШТ-ийн дарга нарын хамтарсан ажлын хэсэг газар дээрх ажилтай танилцахад хүсэлт тавьсны дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан байна.

Эх сурвалж: Аудиторын судалгаа

А.1.3. Орон нутгийн хэрэгцээ шаардлага, санал хүсэлтийн дагуу эрэмбэлсэн төсөл, арга хэмжээ нь улсын төсөвт тусгагдаагүй байна.

Улсын төсвөөр 2021 онд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн үйл ажиллагаанд Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам” мөрдөгдөж байна. Төсвийн тухай хууль болон уг журамд зааснаар аймгийн ТЭЗ нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг хүргүүлэхдээ орон нутгийн хэрэгцээ, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг нь тооцон эрэмбэлсэн байх шаардлагатай.

Улсын төсөвт тусгуулах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлэн аймгийн Засаг даргын 2020 оны 7 дугаар сарын 29-ны өдрийн 1/1643 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Гэвч орон нутагт 2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 4 төсөл, арга хэмжээ батлагдсан нь уг эрэмбэлсэн жагсаалтад багтаагүй байна.

Учир нь орон нутагт Төсвийн тухай хуульд 2021 онд батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээнүүд нь орон нутгийн ТЭЗ-аар дамжин уламжлагдаагүй байна.

Газар дээрх хяналт шалгалт хийн, нөхцөл байдалтай УИХ-ын гишүүд, дээд газрын дарга биечлэн танилцсан бөгөөд мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлтэд үндэслэн тус хөрөнгө оруулалтыг шийдвэрлэсэн байна.

А.2. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх тогтолцоо үр дүнгүй байна.**А.2.1 Өмнөх оноос шилжиж ирсэн ТАХ-нд барилга, байгууламжийн зураг, төслийн ажлын даалгаврыг хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэн боловсруулаагүй, төсөв зургийн дагуу батлагдаагүй зөрчлүүд байна.**

Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.23², 4.1.27³, 22.4⁴, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаал “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга

² 4.1.23. “бие даасан эх үүсвэр, шугам сүлжээ” гэж тухайн барилга байгууламжийн хэрэгцээг хангахад зориулан барих ус, дулаан, уур, хий, цахилгаан, харилцаа холбоо зэрэг инженерийн хангамжийн шугам сүлжээ, байгууламжийг;

³ 4.1.27. “загвар зураг” гэж барилга байгууламжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, орчны тойм, эзлэхүүн төлөвлөлт, барилгын нүүр тал /фасад/, өнгөний шийдэл, төлөвлөлтийг тодорхойлсон баримт бичгийг;

⁴ 22.4. Хүсэлт гаргасан этгээд инженерийн хангамжийн хэрэгцээг өөрийн эх үүсвэрээр хангах зураг төсөл боловсруулан баталгаажуулсан тохиолдолд барилгын ажлын зөвшөөрөл олгож болно.

хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах тайлагнах журам"-ын 7 дахь хэсэг 7.2.2⁵-т, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоол "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх журам"-ын 3.6⁶, 4.4⁷-д зураг, төсөл болон ажлын даалгавар боловсруулах шаардлагыг тусгасан байна.

Өмнөх оноос буюу 2019 оноос хэрэгжиж эхэлсэн дараах төсөл, арга хэмжээнд барилга, байгууламжийн зураг, төслийг захиалагч болон хэрэглэгчийн шаардлагад нийцүүлээгүй байна.

- Баянтүмэн сумын цэцэрлэгийн барилгын /2019-2022/ анхны төсөвт уурын зуухны ажлын 431.9 сая төгрөгийн ажил төсөвт тусгаадаагүй батлагдан, ТАХ хэрэгжиж дуусаагүй байна.
- Баян-Уул сумын соёлын төвийн барилгын /2019-2021/ төсөвт инженерийн байгууламж /цахилгааны сүлжээ болон дотор, гадна сантехникийн шугамын ажил/-ын 519.6 сая төгрөгийн ажил төсөвт тусгаадаагүй батлагдсан байсныг ажил гүйцэтгэж байх хугацаанд буюу 2020-2021 оны төсвийн тухай хуульд нэмж батлагдан 2021 онд хэрэгжиж дууссан байна.

Энэ байдал нь хөрөнгө оруулалтын ТАХ-г жишиг зураг, төсвөөр баталсантай холбоотой бөгөөд тухайн ажлууд хуульд заасан хугацаандаа дуусахгүй, зорилтот үр дүндээ хүрэхгүй байх сөрөг үр дагаврыг үүсгэж байна.

2021 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хувьд зураг, төсвийг хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэн шинээр боловсруулж, батлуулсан байна.

Бусад улсын төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-ний хувьд ажлын даалгаврыг геологийн дүгнэлт, техникийн нөхцөлүүд, газрын зөвшөөрөл зэрэгт үндэслэж, иж бүрэн боловсруулсан байна.

А.2.2 Барилга, байгууламж, засварын ажлын зураг төслийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүд боловсруулж, баталгаажуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шилжин ирсэн 7, шинэ 4 нийт 11 төсөл, арга хэмжээнд барилга байгууламжийн зураг төслийг боловсруулж, баталгаажуулсан хуулийн этгээдүүд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг шинээр болон сунгалт хийлгэж орон нутгийн болон улсын хэмжээнд үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлж явуулаад хэвшсэн туршлагатай хуулийн этгээдүүд оролцсон байна.

Хүснэгт 2. "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнд барилга байгууламжийн зураг төсөл боловсруулж, баталгаажуулсан хуулийн этгээд"

№	Төсөл, арга хэмжээний нэр	Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулсан, баталгаажуулсан хуулийн этгээдийн нэр	Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	
			Олгосон огноо	Дуусах огноо
Шилжих				
1	Мэргэжлийн хяналтын газрын лабораторийн болон конторын барилга /Дорнод, Чойбалсан сум/	“Эй Ди интернешнл” ХХК	2021.06.08 Дугаар 134	2026.06.08
2	Аймгийн Засаг даргын Тамгын газрын барилга /Дорнод, Чойбалсан сум/	“Тулга проект” ХХК	2021.04.14 Дугаар 88	2026.04.14
3	Сумын төвийн нийтийн эзэмшлийн шугамыг инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбох /Дорнод, Халхгол сум/	“Хайдро дизайн прожект” ХХК	2017.11.29 Дугаар 193	2022.11.29
4	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Баянтүмэн сум/	“ДОЗТ” БГБХ нөхөрлөл	2018.11.22 Дугаар 193	2023.11.22
5	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 100 ор /Дорнод, Хэрлэн сум/	“ДОЗТ” БГБХ нөхөрлөл	2018.11.22 Дугаар 193	2023.11.22
6	Соёлын төвийн барилга, 200 суудал /Дорнод, Булган сум/	“Талын хас констракшн” ХХК	2017.03.17 Дугаар 3Т58-296/17	2022.03.17
7	Соёлын төвийн барилга. 250 суудал	“Барилга байгууламж” ХХК	2021.04.28	2026.04.28

⁵ 7.2.2. "Барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх"

⁶ 3.6. Барилгын тухай хуулийн 4.1.27-д заасан загвар зургийг архитектор төлөвлөлтийн даалгавар болон зураг төслийн даалгаврыг үндэслэн боловсруулах бөгөөд аймаг, нийслэлийн ерөнхий архитектор батална.

⁷ 4.4. Иж бүрэн ажлын зураг төслийг зураг төслийн даалгавар, эх загвар зураг /эскиз/-т үндэслэн Барилгын тухай хуулийн 23.3-т заасан үе шатаар боловсруулна.

	/Дорнод, Баян-Уул сум/		Дугаар 97	
Шинэ				
1	Босоо тэнхлэг ба шинэ хотхоны авто зам /Дорнод, Хэрлэн сум/	“ХЗТ авто зам” ХХК	2018.01.25 Дугаар 17	2023.01.25
2	Цэцэрлэгийн барилгын худгийн насос, шугам сүлжээний засвар /Дорнод, Хэрлэн сум, 12 дугаар цэцэрлэг/	“ДОЗТ” БГБХ нөхөрлөл	2018.11.22 Дугаар 193	2023.11.22
3	УЦУОШТ-ийн конторын барилгын дээврийн засвар /Дорнод/	“Нью Бест Дизайн” ХХК	2017.12.14 Дугаар 203	2022.12.14
4	УЦУОШТ-ийн конторын барилгын дээврийн засвар /Дорнод, Баян-Уул/	“Нью Бест Дизайн” ХХК	2017.12.14 Дугаар 203	2022.12.14

Эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яамны сайт – тусгай зөвшөөрөл <https://mcud.gov.mn/p/c/40>

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээнд зураг төслийг боловсруулахад оролцсон нийт 8 хуулийн этгээдүүдийн хувьд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй ба хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд орон нутагт хэрэгжиж буй нийт 11 төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн зураг төслийг боловсруулж, баталгаажуулсан хуулийн этгээдийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүрэн хангалттай байна.

А.2.3. Барилгын засварын ажлын зураг төсөвт олгосон зардлыг бодит гүйцэтгэл, жишиг үнэд үндэслэсэн байна.

БХБС-ын 2020 оны 108 дугаар тушаал “Зураг төслийн ажлын жишиг үнэ” /БД 81-16-20/-д зааснаар барилга байгууламжийн засварын ажлын зураг төслийн үнийг тухайн барилгын төвөгшлийн ангиллаас хамааруулан засварын ажлын төсөвт өртгийн дүнгээс 3.0-4.0 хувиас багагүй хувиар, “Авто зам гүүрийн зураг төслийн жишиг үнэ, түүнийг хэрэглэх заавар”-т зааснаар авто замын зургийн ерөнхий гүйцэтгэгчийн замын трасс сонгох, түүнтэй уялдсан бусад төслийн ажилд оролцох болон холбогдох барилга байгууламжийн байршлыг сонгох зэрэг ажлын үнийг тухайн ажлын үнийн 5.0 хүртэл хувиар, $c=(a+bx)k_1$ томъёогоор тооцох журмын заалттай.

Зураг, төсвийн үнийг жишиг үнэд харьцуулсан харьцааг дараах судалгаагаар үзүүлэв.

Хүснэгт 3. “Зураг, төсвийн үнийг жишиг үнэд харьцуулсан шинжилгээ”

№	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг /сая.төг/	Зураг төсөв боловсруулсан байдал				Жишиг үнэ /хувь/	Зөрүү
			Гүйцэтгэгч	Зураг, төсвийн үнэ	Олгосон байдал	Төсөвт эзлэх хувь		
1	Босоо тэнхлэг ба шинэ хотхоны авто зам /Дорнод, Хэрлэн сум/	2,000.0	"ХЗТ-Авто зам" ХХК	50.0	50.0	2.5	5.0 хүртэл	-
2	"Цэцэрлэгийн барилгын худгийн насос, шугам сүлжээний засвар /Дорнод аймаг, Хэрлэн сум, 12 дугаар цэцэрлэг/"	64.1	"ДОЗТ" БГБХН	1.8	1.8	2.8	3.0-4.0 багагүй	0.2
3	УЦУОШТ-ийн конторын барилгын дээврийн засвар /Дорнод/	10.0	"Нью бест дизайн" ХХК	0.2	-	2	3.0-4.0 багагүй	1.0
4	УЦУОШТ-ийн конторын барилгын дээврийн засвар /Дорнод, Баян-Уул/	10.0		0.2	-	2		

Эх сурвалж: Төсөл, арга хэмжээний төлөөлөлтийн судалгаа

2021 онд хэрэгжсэн ТАХ-ний зураг төсвийн жишиг үнийг төсөвт өртгийн 2-2.8 хувиар тооцсон нь “Зураг төслийн ажлын жишиг үнэ” /БД 81-16-20/-ийн 4.9.3-т зааснаас 0.2-1.0 хувиар бага тооцож, санхүүжилтийг олгосон нь журмыг заалтыг баримталсан байна.

Шинээр болон он дамжин хэрэгжиж байгаа 2019-2021 оны 11 ТАХ-ний зураг, төслийн гэрээний дагуу 292.9 сая төгрөгийг олгохоос 290.6 сая төгрөгийг олгосон

байна. Үүнээс зураг, төсөв боловсруулах гэрээний хугацааг баримтлаагүйтэй холбоотой 3 ажилд 1.9 сая төгрөгийг алдангид тооцсон нь үндэслэлтэй байна.

УЦУОШТ-ийн конторын барилгын дээврийн засвар /Дорнод, Хэрлэн, Баян-Уул сум/-ын ажилд зураг, төсвийг гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулаагүйтэй холбоотой УЦУОТ-өөс санхүүжилтийг олгоогүй байна.

ЗТХС-ын баталсан “Авто зам, гүүрийн зураг төслийн жишиг үнэ, түүнийг хэрэглэх заавар”-ын холбогдох заалтыг баримталсан байна.

А.2.4. Өмнөх оноос шилжиж ирсэн аймгийн Засаг даргын Тамгын газрын барилгын төсөвт 4 удаа өөрчлөлт орсон байна.

Өмнөх оноос шилжиж ирсэн буюу 2011 оноос хойш хэрэгжиж байгаа аймгийн Засаг даргын тамгын газрын барилга /Дорнод, Хэрлэн/-ын хувьд төсөвт өртөг 4 удаа өөрчлөгдөн зураг, төсөвт магадлал хийгдсэн байна. Тус төсөл, арга хэмжээ нь 2011 оны төсвийн тухай хуульд 3,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр батлагдаж, 2015 онд 6,541.0, 2021 онд 7,499.6, 2022 онд 9,130.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй байхаар батлагдсан байна. Хамгийн сүүлд буюу 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн магадлалын ерөнхий дүгнэлтээр 3,142.1 сая төгрөгөөр төсөвт өртөг нэмэгдсэн байна.

А.2.5. Магадлалын ерөнхий дүгнэлтээр шинээр хэрэгжих 1 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдсэн байна.

Тайлант онд шинээр хэрэгжсэн ажлаас “Босоо тэнхлэг ба шинэ хотхоны авто зам /Дорнод, Хэрлэн сум/”, 2,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг магадлалын ерөнхий дүгнэлтээр 2,099.2 сая төгрөг буюу төсөв 99.2 сая төгрөгөөр зөрүүтэй байдлаар баталгаажуулсан байна. Энэ нь цаашид төсөвт өртөг, ажлын гэрээний дүн нэмэгдэх магадлалтайг харуулж байна.

А.3.Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх бодлогын хэрэгжилтийг хангуулаагүй байна.

А.3.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нь ТЕЗ-ын хөрөнгө оруулалтын эрэмбэлсэн жагсаалтад багтаагүй учир хэрэгцээ шаардлагыг үнэлэх боломжгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд орон нутагт шинээр батлагдсан 4 төсөл, арга хэмжээний 3 төсөл, арга хэмжээ нь дээд шатны байгууллагад хүсэлт хүргүүлж, УИХ-ын гишүүдийн дэмжлэгтэйгээр салбарын сайдын багцад багтаж хийгдсэн ба бүгд их засварын ажил тул тухайн байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй явуулах боломжийг хангаж байна. Харин “Босоо тэнхлэг ба шинэ хотхоны авто зам” /Дорнод, Хэрлэн сум/ төсөл, арга хэмжээний хувьд УИХ-ын гишүүний санаачилгаар дэмжигдэж батлагдсан төсөл, арга хэмжээ ба ашиглалтад бүрэн орсон тохиолдолд хэрэгцээ шаардлагыг үнэлэх боломжтой болно.

Хүснэгт 4. “Эрх шилжин 2021 онд бүрэн ашиглалтад орсон 2 төсөл, арга хэмжээний хувьд хэрэгцээ шаардлага, хүчин чадал”

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгцээ шаардлага	Хүчин чадал
1	Соёлын төвийн барилга, 250 суудал /Дорнод, Баян-Уул сум/	Зориулалтын бус барилгад соёл урлагийн үйл ажиллагаа явуулахад цуурайтаж, нэгдсэн халаалтгүй, галлаж үйл ажиллагаагаа явуулдаг байсантай холбоотойгоор тав тух муутай, тасралтгүй үйл ажиллагаа явуулах боломжгүй стандартад нийцдэггүй байна. Сумын хүн амын тоо – 4735, сургуулийн сурагчдын тоо – 1017. (2022 оны байдлаар)	200 хүний суудалтай гэх боловч 100 гаран хүний багтаамжтай үйл ажиллагаагаа явуулдаг байсан. Мөн соёлын төвийн албан хаагчдын хувьд ажиллах орчин нөхцөл муу, ажлын чиг үүргийн дагуу үүргээ биелүүлэхэд зориулалтын зай талбай, тав тухтай зориулалтын соёлын барилга зайлшгүй үүссэн байна.
Одоогийн ашиглалт		Уг соёлын төв нь 2022 оны байдлаар төвийн халаалттай 250 хүний суудалтай нийт сургуулийн сурагчдын хувьд номын санг бүрэн ашиглаж, уншлагын танхимтай болсноор өмнө жилд 400 гаран хүнд үйлчилдэг байсан бол одоо 1 сард дунджаар 400 хүнд үйлчилж, соёл хүмүүжлийн	

		ажил сумын хэмжээнд ихээр нэмэгдсэн байна. Мөн соёл урлагийн чиглэлийн үйл ажиллагаа тасралтгүй явагдаж үзэгчдийн тоо өссөн байна.	
2	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 100 ор /Дорнод, Хэрлэн сум/	9-р багийн нутаг дэвсгэрт оршин суудаг хүүхдүүдийн хамран сургалтад хамрагдах тоо их, СӨБ-ын стандартад нийцэхгүй анги дүүргэлт их байсан байна. Цэцэрлэгийн үйл ажиллагааг өргөжүүлэх санал, хүсэлтийг удаа дараа хүргүүлсэн байна.	Анги дүүргэлт 1 ангид 40 хүүхэдтэйгээр сургалтын үйл ажиллагаагаа явуулж, аюулгүй эрүүл орчин нөхцөл бүрдэхгүй байсан байна.
Одоогийн ашиглалт		Уг цэцэрлэг ⁸ нь 2022 оны байдлаар 1 анги дүүргэлт 25-30 хүүхэдтэйгээр өргөтгөлийн байрыг бүрэн ашиглаж СӨБ-ын стандартын дагуу орчинд сургалтын үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байна.	

Эх сурвалж: Аудиторын судалгаа

ТЕЗ-ын хөрөнгө оруулалтын эрэмбэлсэн жагсаалтад багтаагүй төсөл, арга хэмжээ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн байна.

А.3.2. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Шинээр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.11⁹-д заасны дагуу орон нутагт улсын төсвөөр батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд бүгд зураг төсөлтэй тусгагдсан байна.

Хүснэгт 5. “Шинээр орон нутагт 2021 онд хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээ”

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая.төгрөг/	ТАХ-ний жагсаалт батлагдсан огноо	Зураг төсөл батлагдсан огноо
1	Босоо тэнхлэг ба шинэ хотхоны авто зам /Дорнод, Хэрлэн сум/	2,000.0	2020.11.13	2021.05.13
2	Цэцэрлэгийн барилгын худгийн насос, шугам сүлжээний засвар /Дорнод, Хэрлэн сум, 12 дугаар цэцэрлэг/	64.1	2020.11.13	2020.11.25
3	УЦУОШТ-ийн конторын барилгын дээврийн засвар /Дорнод/	10.0	2020.11.13	2021/02
4	УЦУОШТ-ийн конторын барилгын дээврийн засвар /Дорнод, Баян-Уул/	10.0	2020.11.13	2021/03

Эх сурвалж: Аймгийн ГХБХБГ-ын 2022.03.11-ний өдрийн төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн судалгаа

Орон нутагт 2021 онд хэрэгжсэн 2 төсөл, арга хэмжээ нь ТАХ-ний жагсаалт батлагдсан хугацаанаас хоцорч зураг төсөл нь батлагдсан байна.

А.3.3. Төсөл арга, хэмжээний санхүүжилт нь хэрэгжих боломжтой байдлаар батлагдсан байна.

Тайлант онд шинээр хэрэгжихээр эрх шилжиж ирсэн 4 төсөл, арга хэмжээний санхүүжилт 2,084.1 сая төгрөгөөр, өмнөх оноос шилжиж ирсэн 7 төсөл, арга хэмжээний санхүүжилт 4,447.6 сая төгрөгөөр тус тус батлагдсан байна.

Эдгээрээс тайлант онд эрх шилжиж ирсэн 3 төсөл, арга хэмжээний 84.1 сая төгрөгийн санхүүжилт хугацаандаа олгогдож ажил нь хийгдсэн, 2,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний ажил нь бүрэн хийгдээгүй, санхүүжилт нь Зам тээврийн хөгжлийн яамнаас олгогдож байна.

Өмнөх оноос шилжиж ирсэн 8,482.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээний 2,917.8 сая төгрөгийн санхүүжилт хугацаандаа бүрэн олгогдож, ажил нь хийгдсэн байна. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын барилга, Булган сумын Соёлын төвийн барилга гэсэн нийт 9,117.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээ дараа онд хэрэгжих боломжтой байдлаар санхүүжилт нь батлагдсан байна.

⁸ Уг 1-р цэцэрлэг нь 9-р багийн нутаг дэвсгэрт байрладаг бөгөөд аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын даргын 2020 оны А/08 тушаалаар “Дорнод аймгийн төрийн өмчийн цэцэрлэгүүдэд харьяалах тойрог”-т зааснаар Хэрлэн сумын 5, 6, 9, 10, 11, 60 дугаар байруудын СӨБ-д хамрагдах хүүхдүүд багтаж байна.

⁹ зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахгүй байх;

А.3.4. Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөж батлаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-д "Хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг", 68 дугаар зүйлийн 68.2-д "Төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэх явцад нэмж тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн шатны төсвийг өргөн мэдүүлсэн этгээдээс энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар санал, дүгнэлтийг авсны үндсэн дээр тусгана.", Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10-д "Санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх" гэснийг үндэслэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг боловсруулж, батлуулах хуулийн заалттай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжихээр эрх нь шилжиж ирсэн нийт 4 төсөл, арга хэмжээний 1 нь авто замын бүтээн байгуулалт, 3 нь барилга байгууламжийн хэсэгчилсэн засвар, дулааны шугам сүлжээний засварын ажил батлагдаж, хэрэгжсэн байна. Төсвийн тухай хуульд холбогдох сайдын их засварын багцаас 84.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээг аймгийн Засаг дарга болон Ус, цаг уур, орчны шинжилгээний төвд шилжүүлсэн байна.

Хүснэгт 6. "Барилгын засварын ангилал"

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая.төг/	ТЕЗ-ийн нэр	Эрх хүлээн авсан төсвийн захирагч	Засварын ажлын ангилал
1	"Цэцэрлэгийн барилгын худгийн насос, шугам сүлжээний засвар /Дорнод аймаг, Хэрлэн сум, 12 дугаар цэцэрлэг/"	64.1	БШУС	Аймгийн ЗД	Барилгын их засвар
2	УЦУОШТ-ийн конторын барилгын дээврийн засвар /Дорнод/	10.0	БОАЖС	Аймгийн УЦУОШТ	Барилгын засвар
3	УЦУОШТ-ийн конторын барилгын дээврийн засвар /Дорнод, Баян-Уул/	10.0	БОАЖС	Аймгийн УЦУОШТ	Барилгын засвар

Эх сурвалж: Эрх шилжүүлсэн тушаал, Барилга, байгууламжийн ашиглалтын жишиг норм

Цэцэрлэгийн барилгын шугам сүлжээ, УЦУОШТ-ийн конторын барилгын дээврийн засвар нь "Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм"-ын 2.3.7¹⁰, 2.3.9¹¹-д зааснаар барилгын их засвар болон барилгын засварын ангилалд хамаарч байна.

Үүнээс дүгнэж үзэхэд 2021 онд орон нутагт хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төсөл, арга хэмжээг төлөвлөж батлаагүй байна.

Б. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалт үр дүнтэй байна.

Б.1. Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

Б.1.1. Хөрөнгө оруулалтын 2,064.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ-ний эрхийг холбогдох журамд заасан хугацаанаас хоцроож шилжүүлсэн байна.

Дорнод аймгийн хэмжээнд 2021 онд шинээр хэрэгжүүлэх 4 төсөл, арга хэмжээний эрхийг холбогдох салбарын сайдаас шилжүүлсэн байна.

Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг

¹⁰ 2.3.7."Барилгын засвар" гэж барилгын техник эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг хөндөлгүйгээр физик ба моралийн элэгдлийг арилгахаар хийгддэг техник зохион байгуулалтын арга хэмжээ болон барилгын ажлын цогцыг;

¹¹ 2.3.9."Барилга байгууламжийн их засвар" гэж шаардлагатай үед барилгын бүтээцийн бүрдэл хэсэг ба инженерийн тоног төхөөрөмжийг солих, засаж сэлбэх, мөн түүнчлэн ашиглалтын байдлыг сайжруулах зорилгоор хийгддэг барилгын засварыг;

төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.13-д заасны дагуу 2021 оны төсвийн тухай хууль 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсанаас хойших хугацаагаар тооцоход захиалагч хуулиар өөрт олгогдсон эрхийг 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр хүртэл буюу 60 хоногийн дотор шилжүүлэхээр байна.

Дээрх журмын дагуу захиалагчаас холбогдох албан тушаалтанд эрх шилжүүлсэн хугацааг тооцоход Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаас 20.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээний эрхийг Дорнод аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвд хугацаанд нь эрх шилжүүлсэн байна.

Зам тээврийн хөгжлийн сайдаас 2,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний эрхийг 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдөр шилжүүлсэн нь 27, Боловсрол, шинжлэх ухааны сайдаас 64.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний эрхийг 2021 оны 4 сарын 23-ны өдөр шилжүүлсэн нь 101 хоногоор тус тус хоцроосон байна.

Б.1.2. Төсөл, арга хэмжээг тайлант онд хэрэгжих боломжтой хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Эрх шилжиж ирсэн 2,084.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээнээс 84.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг тайлант онд хэрэгжих боломжтой байдлаар зохион байгуулсан боловч 2,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 5 удаа зохион байгуулснаас шалтгаалан гэрээ байгуулж гүйцэтгэх ажил оройтсон байна. Худалдан авах ажиллагааг 5 удаа зохион байгуулах болсон нь ТАХ-ний тендерийг 2 удаа зарлахад оролцогчоос санал ирүүлээгүй, 3 дахь удаа зарлахад 1 оролцогчоос, 4 дэх удаа зарлахад 3 оролцогчоос тус тус санал ирүүлсэн боловч тендерийн баримт бичгийн шаардлагыг хангаагүй гэж, 5 дахь удаа зарлахад 2 оролцогчоос санал ирүүлснээс 1 оролцогчийн санал шаардлагад нийцэж сонгон шалгаруулсан байна.

Б.1.3. Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулж, батлуулсан байна.

Эрх нь шилжиж ирсэн 2 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороод нь тендерийн баримт бичгийг ТБОНӨХБАҮХАТХ болон Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу боловсруулж батлуулсан байна.

Б.1.4. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй байдлаар сонгон шалгаруулсан байна.

Дорнод аймагт шинээр эрх шилжиж ирсэн 2,064.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй, цахим хэлбэрээр зохион байгуулж, тендерийн зарыг өдөр тутмын сонинд тавьсан байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааны талаар өргөдөл, гомдол гараагүй байна.

Б.1.5. ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны тайланг Шилэн дансны хууль журамд заасны дагуу цахим хуудаст ил тод мэдээлээгүй байна.

Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 4.2-д "Төсвийн ерөнхийлөн захирагч, ... нь тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг энэ журмын хавсралт маягт 2-ын дагуу цахим системд хянан нэгтгэж, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим системээр ирүүлнэ." гэж заасан байна.


Дээрх журмын дагуу аймгийн ТЕЗ улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны тайланг хугацаанд нь Сангийн яамд тайлагнасан боловч Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлээгүй байна. ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой албан шаардлагыг 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр хүргүүлсэн болно.

Б.2. Захиалагч гэрээний хэрэгжилтийг хангуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулаагүй байна.

Б.2.1. Гүйцэтгэгчид төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд дуусгаагүй, дутуу гүйцэтгэсэн зөрчлүүд илэрч байна.

Барилгын тухай хуулийн 40.2¹², Иргэний тухай хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.1¹³, 350.1.4¹⁴, 350.1.7-д заасан болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд гүйцэтгэгч нь зураг, төслийн дагуу ажил, үйлчилгээг хугацаанд нь буюу чанартай гүйцэтгэх, ашиглалтын явцад үр дүнгийн доголдлыг арилгахаар заасан байна. Харин гэрээний хугацаа, чанар, ашиглалттай холбоотой дараах зөрчлүүд илэрч байна.

Дүрслэл 1. "ТАХ-ний хэрэгжилт /хувиар/"



Дорнод аймагт улсын төсвөөс эрх нь шилжсэн шинэ 4, өмнөх оноос шилжиж ирсэн 7, нийт 11 ТАХ байгаагаас 2021 онд хэрэгжиж дууссан 6, он дамжин гүйцэтгэгдэх 5 төсөл, арга хэмжээ байна.

Эх сурвалж: "ТАХ-ны хэрэгжилтийн судалгаа №3"

Хүснэгт 7. "Гэрээний хугацаанд дуусгаагүй, ашиглалтад ороогүй ТАХ"

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая.төг/	Хэрэгжилт /хувь/	Гүйцэтгэгч ААН	Тайлбар, шалтгаан
1	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Баянтүмэн сум/	1,731.9	70	"Талын сүлд" ХХК	Зураг төсвийн магадлалаар төсөвт өөрчлөлт орж, ажил хойшлогдсон.
2	Соёлын төвийн барилга, 200 суудал /Дорнод, Булган сум/	1,617.8	0	"ЦОДММ" ХХК	Гүйцэтгэгч гэрээний үүргээсээ татгалзаж, ХАА дахин зарлаж, "ЦОДММ" ХХК шалгарсан.

Эх сурвалж: ТАХ-ний гэрээний хэрэгжилтийн судалгаа №3

1. Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Баянтүмэн сум/-ын ажлыг "Талын сүлд" ХХК 2019-2020 онд гүйцэтгэж, гүйцэтгэл 70 хувьтай байна. Зураг төсвийн магадлалаар инженерийн байгууламжийн ажил нэмэгдэж, нийт төсөвт өртөг 1,731.9 сая төгрөг болж өөрчлөгдөн улсын төсөвт батлагдсан. Үүнээс 2021 оны төсөвт 50.0 сая төгрөг, 2022 оны төсөвт үлдсэн 522.8 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн нь төсөл, арга хэмжээний үр ашгийг бууруулж байна.

¹² 40.2.Барилгын ажлыг зураг төсөлгүйгээр гүйцэтгэхийг хориглоно.

¹³ 350.1.1.гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх;

¹⁴ 350.1.4.ажил гүйцэтгүүлэхээр захиалагчаас олгосон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах талаар өөрөөс шалтгаалах бүхий л арга хэмжээ авах;

350.1.7.ажлын үр дүнгийн доголдлыг арилгахад шаардагдах зардлыг /ажлын хөлс, материалын зардал, замын хураамж болон тээврийн хөлс г.м/ хариуцах;



Барилгын ажлын явц 70 хувьтай, гэрээг 2022 онд дуусахаар сунгасан.

2. Соёлын төвийн барилга, 200 суудал /Дорнод, Булган сум/-ын ажлыг “Талын сувд” ХХК 2020-2021 онд гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч, 2020 онд барилгын материалын үнэ өссөн шалтгаанаар тус ажлыг гүйцэтгэхээс татгалзсан байна. Аймгийн Орон нутгийн өмчийн газраас тендерийг 2021 оны 7 дугаар сараас 3 удаа зарлаж, оролцогч байхгүй шалтгаанаар “ЦОДММ” ХХК-ийг шалгаруулж, 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, 2021 онд ажил оройтож эхэлсэн шалтгаанаар тус компаниас ажлын гүйцэтгэл гараагүй байна.

Аудитын явцад 2021 онд хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг газар дээр нь үзэхэд гүйцэтгэл дутуу байхад хүлээж авсан болон ашиглалтын явцад асуудал үүссэн дараах ажлууд байна. Үүнд:

1. Соёлын төвийн барилга, 250 суудал /Дорнод, Баян-Уул сум/-1,797.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил:

Тус ажлыг “Дорнын оч” ХХК 2019-2021 оны хугацаанд гүйцэтгэж ашиглалтад оруулсан байна. Ашиглалтын явцад барилгын зураг, төсөвт өрөө хоорондын агааржуулалт тусгагдаагүйгээс чийгшилтэй холбоотой асуудал үүсэж өрөөнүүдийн хана, таазанд цана цохиж, мөөгөнцөр үүссэн, залны шал хөндийрсөн, дуу тусгаарлах хавтан зарим газраа ховхорсон, цэвэр усны шугам хөлдөж, өнгөрсөн 2021 оны хүйтний улиралд 00 ажиллагаагүй, хүйтэн усгүй байсан байна.



Соёлын төвийн барилга ашиглалтын явцад агааржуулалттай холбоотой асуудал үүссэн байна.


2. УЦУОШТ-ийн конторын барилгын дээврийн засвар /Дорнод/-10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил:

Дээвэр болон барилгын гадна талын өнгө үзэмжийг сэргээх ажлыг “Өршөөлтийн ариун” ХХК 2022.11.01-11.18-ныг хүртэл гүйцэтгэж, хүйтний улирал эхэлсэнтэй холбогдуулан дээврийн засварын үе шатны ажлыг дутуу гүйцэтгэж, дулааны улирал эхлэхэд үлдсэн ажлыг хийж гүйцэтгэхээр тохиролцсон байна.



3. УЦУОШТ-ийн конторын барилгын дээврийн засвар /Дорнод, Баян-Уул/-10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил:

Конторын барилгын дотор болон гадна засварын ажлыг “Улзын хүч” ХХК 2022.11.15-12.01-нийг хүртэл гүйцэтгэж, хүйтний улирал эхэлсэнтэй холбогдуулан гадна талыг сэргээх ажлыг дутуу гүйцэтгэж, дулааны улиралд үлдсэн ажлаа гүйцээж хийхээр тохиролцсон байна. Мөн зураг, төсөвт шалны ажлыг паркет байсныг барилгын онцлог нөхцөл байдалд тохируулж хулдаас болгон өөрчилсөн нь зураг, төсвийн дагуу бүрэн хийгээгүй байна.



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2021 ОНД АШИГЛАЛТАД ХҮЛЭЭЖ АВСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ



1 соёлын төвийн барилга /Баян-Уул сум/



1 цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Хэрлэн сум/



2 УЦУОШТ-ийн барилгын гадна болон дээврийн засвар /Хэрлэн, Баян-Уул сум/



1 цэцэрлэгийн шугам сүлжээний засвар /Хэрлэн сум/



1 сумын инженерийн шугам сүлжээ /Халхгол сум/

НИЙТ 3,827.2 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ

Б.2.2. Шинээр хэрэгжсэн барилгын засварын ажилд зохиогч, мэргэжлийн байгууллагын хяналт хэрэгжээгүй байна.

Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагч, зохиогчийн хяналтын хэрэгжүүлэхэд Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоол “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.4¹⁵, 3.12¹⁶, Барилга, хот байгуулалтын

¹⁵ 3.4.Захиалагч барилгын ажлын явц, үе шатанд тавих хяналтыг гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч болон барилгын үйл ажиллагаанд оролцогч бусад этгээдтэй хамтран гэрээний үндсэн дээр өдөр, сар, улирал бүрээр гүйцэтгэнэ.

¹⁶3.12. Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно.

сайдын 2016 оны 178 дугаар тушаал “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 4.3.1¹⁷ дэх заалтуудыг баримтлахаар тусгайлан заасан. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд ТАХ-ний нэршлээр батлагдаж, ЗТХС-аас эрхийг шилжүүлсэн “Босоо тэнхлэг ба шинэ хотхоны авто зам /Дорнод, Хэрлэн сум/”, холбогдох БОАЖС, БСШУС-ын багцаас эрх шилжүүлсэн “Цэцэрлэгийн барилгын худгийн насос, шугам сүлжээний засвар /Дорнод, Хэрлэн сум, 12 дугаар цэцэрлэг/, “УЦУОШТ-ийн конторын барилгын дээврийн засвар /Дорнод/”, “УЦУОШТ-ийн конторын барилгын дээврийн засвар /Дорнод, Баян-Уул/-ын ажлууд байна.

“Босоо тэнхлэг ба шинэ хотхоны авто зам /Дорнод, Хэрлэн сум/”-ын ажилд зохиогчийн хяналтыг “ХЗТ автозам” ХХК, захиалагчийн хяналтыг аймгийн ЗДТГ нь “Танил санаа” ХХК-иар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхээр заасан байна. Цэцэрлэгийн барилгын худгийн насос, шугам сүлжээний засвар /Дорнод, Хэрлэн сум, 12 дугаар цэцэрлэг/-ын ажилд захиалагчийн хяналтыг аймгийн ГХБХБГ, зохиогчийн хяналтыг “ДОЗТ” БГБХН хэрэгжүүлж, тайлагнасан байна.

“УЦУОШТ-ийн конторын барилгын дээврийн засвар /Дорнод/”, “УЦУОШТ-ийн конторын барилгын дээврийн засвар /Дорнод, Баян-Уул/”-ын ажлуудад зохиогчийн болон мэргэжлийн байгууллагын захиалагчийн хяналт хэрэгжээгүй байна. Өмнөх онуудаас 2019-2021 онд эрх нь шилжсэн ажлуудад захиалагчийн хяналтыг аймгийн ГХБХБГ, зохиогчийн хяналтыг зураг, төсөв зохиосон аж ахуйн нэгжүүд үр дүнтэй хэрэгжүүлж, тайлагнасан байна.

Б.2.3. Хөрөнгө оруулалтаар техник, тоног төхөөрөмж бэлтгээгүй байна.

Хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжихээр эрх шилжиж ирсэн 4 төсөл, арга хэмжээний 1 нь авто зам, 3 нь их засварын ажил байгаа бөгөөд техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл, арга хэмжээ байхгүй байна.

Б.2.4. Өмнөх онуудаас хэрэгжиж дуусаагүй орхигдсон 4,270.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга, байгууламж байна.

Өмнөх онуудаас хэрэгжиж дуусаагүй, орхигдсон 4,270.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 барилга, байгууламж байна.

Хүснэгт 8. “Орхигдсон барилга, байгууламжийн судалгаа”

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая.төг/	Хэрэгжилт /хувь/	Гүйцэтгэгч ААН	Тайлбар, шалтгаан
1	Улз голын урсцыг нэмэгдүүлэх “Онон-Улз” төсөл /Дорнод, Баяндун сум/	2,500.0	41.5	“Вэлмот” ХХК	Гүйцэтгэгчийн ажиллагаанаас шалтгаалсан. үйл
2	Спорт цогцолборын өргөтгөл, усан бассейн /Дорнод, Хэрлэн сум/	1,770.3	21.7	“Билиг” ХХК	Гүйцэтгэгчийн ажиллагаанаас шалтгаалсан. үйл
Нийт		4,270.3			

Эх сурвалж: ГХБХБГ-ын судалгаа №4.

¹⁷ 4.3.1.илэрсэн зөрчил, гэмтэл, түүний шалтгаан, арилгах арга зам, засварлах хугацааг заах;



Улз голын урсцыг нэмэгдүүлэх "Онон-Улз" төслийн явц - 41,5 хувь

1. Улз голын урсцыг нэмэгдүүлэх "Онон-Улз" төсөл /Дорнод, Хэрлэн сум/-ийг "Вэлмот" ХХК 2,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр 2019-2020 онд гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Үүнээс 2019 онд 1,100.0 сая төгрөг батлагдаж, 221.0 сая төгрөг зураг төсвийн зардалд зарцуулагдаж, 879.0 сая төгрөгийг гүйцэтгэлд санхүүжүүлэхээр төлөвлөсөн боловч зураг төсөв оройтож хийгдсэн шалтгаанаар тухайн онд гүйцэтгэл хийгдээгүй байна. Өнгөрсөн 2020 онд 681.4 сая төгрөгийн гүйцэтгэл хийгдэж, тухайн онд хийгдэх гүйцэтгэлд хүрээгүй учраас үлдэгдэл 197.6 сая төгрөгийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулан 2021 онд нэмж төсөв батлагдаагүй, тухай төсөл, арга хэмжээ царцаагдсан байна.

Тус төсөл, арга хэмжээ нь гүйцэтгэгч компанийн үйл ажиллагаанаас шалтгаалан цаашид хэрэгжихгүй нөхцөл байдал үүссэн учраас БОАЖЯ-нд одоогийн хийгдсэн байгууламжийг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар дүгнэлт гаргуулж, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх талаар уламжилж шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.

2. Спорт цогцолборын өргөтгөл, усан бассейн /Дорнод, Хэрлэн сум/-ны ажлыг "Билиг" ХХК 1,770.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр 2011-2015 онд гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Хуучин 800 машины гарааж буюу "Билиг" ХХК-ийн өөрийн өмчлөлийн газар, барилгын төмөр хийц бүхий байгууламжийн зүүн хэсэг болох 648м² талбайг төр худалдан авч, тус компаниар гүйцэтгүүлсэн боловч 2011-2012 онд 384.0 сая төгрөгийн гүйцэтгэл гаргаж, барилга байгууламжийн явц 21.7 хувьд хүрсэн боловч компанийн үйл ажиллагаатай холбоотой барилгын ажил бүрмөсөн зогссон байна.

Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2013 оны дүгнэлтээр тус бетон карказын ашиглалтыг тодорхойлуулах талаар дүгнэлт гаргасны дагуу 2013 онд ШУТИС-ийн Барилга, архитекторын сургуулийн дэргэдэх мэргэжлийн баг, Монгол Улсын зөвлөх инженер, улсын экспертийн дүгнэлтээр тус барилгын хийцийг ашиглаж болно гэсэн дүгнэлт гарч байсан. Хамгийн сүүлд буюу 2020 онд цементэн /бетон/ хана бүхий цутгамал шал, хана бүхий байгууламжийн хийц технологи нь барилга, норм, стандартад нийцэхгүй учраас цаашид ашиглах боломжгүй талаар ШУТИС-ийн Барилга, архитекторын сургуулийн дэргэдэх мэргэжлийн баг /шинжээч/-ийн дүгнэлт гарсан байна.

Иймд тус царцаагдсан буюу орхигдсон барилга байгууламжийн хэрэгцээ, шаардлагагүй байдал, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн газар, объектыг дуудлага худалдаанд оруулах замаар эдийн засгийн эргэлтэд оруулах талаар арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй байна.



Спорт цогцолборын өргөтгөл, усан бассейны ажил царгцаагдсан байдал.

Б.2.5. Хөрөнгө оруулалтаар орон нутагт хийж гүйцэтгэсэн зураг, төслийг холбогдох хууль, барилгын норм, дүрэм, стандартын дагуу боловсруулж, 2021 онд холбогдох төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд ашигласан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 оны байдлаар хэрэгжүүлсэн 4 төсөл, арга хэмжээний зураг, төсөл боловсруулалт, хууль, дүрмийн ашиглалтын хувьд ТАХ-ний жагсаалтаас хоцорч батлагдсан 2 төсөл арга хэмжээний зураг төсөл байна. Хугацаандаа батлагдсан зураг, төсөлтэй 2 ТАХ нь захиалагчийн хяналтыг хувийн мэргэжлийн ААН болон аймгийн ГХБХБГ-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.

Хүснэгт 9. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээний зураг, төсөл боловсруулалт, хууль, дүрмийн ашиглалт”

№	Төсөл, арга хэмжээний нэр	Зураг төсөл батлагдсан огноо	Зургийн даалгавар батлагдсан огноо	Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд ашигласан хууль, дүрэм	Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3 ¹⁸ дахь заалтын хүрээнд
1	Босоо тэнхлэг ба шинэ хотхоны авто зам /Дорнод, Хэрлэн сум/	2021.05.13	-		Захиалагчийн хяналтыг мэргэжлийн хувийн ААН-тэй гэрээ байгуулж гүйцэтгүүлж байна.
2	Цэцэрлэгийн барилгын худгийн насос, шугам сүлжээний засвар /Дорнод, Хэрлэн сум, 12 дугаар цэцэрлэг/	2020.11.25	Шаардлагагүй	Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 43 дугаар тушаалын 1-р хавсралт.	Захиалагчийн хяналтыг аймгийн ГХБХБГ-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн.
3	УЦУОШТ-ийн конторын барилгын дээврийн засвар /Дорнод, Хэрлэн сум/	2021/02	Шаардлагагүй	-	-
4	УЦУОШТ-ийн конторын барилгын дээврийн засвар /Дорнод, Баян-Уул сум/	2021/03	Шаардлагагүй		

Эх сурвалж: Аудиторын судалгаа

Барилгын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.3-т “Зураг төсөл зохиогч хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх” гэж заасны дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний зураг, төсөл нийцэж байна.

УТХО-аар хийгдэж буй энэ аудитыг жил бүр хийж зөвлөгөө өгч, хяналтыг хийдэгтэй холбоотойгоор оролцож буй оролцогчдын гүйцэтгэл хуулийн дагуу хийгдэж хэвшсэн байна.

Б.3. Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

Б.3.1. Хяналтын тогтолцоо бүрдсэн боловч 2 барилгын засварын ажилд мэргэжлийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагатай гэрээ байгуулаагүй, үр дүнг тооцоогүй байна.

¹⁸ барилга байгууламжийн байршил тогтоох, газар олголт, загвар зураг батлах болон техникийн нөхцөл олгох үйл ажиллагааг зохион байгуулж, нэгдсэн бүртгэл хөтлөх, хадгалах, мэдээлэл түүний аюулгүй байдлыг хангах, мэдээллийн сангийн байнгын үйл ажиллагааг эрхлэх, хяналт тавих;

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоол “Барилгын ажлын захиалагчийн хяналтын дүрэм”-ийн 3.12-д “Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно.”, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаал “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 1.2-д “Бүх төрлийн барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, засварлах, тоноглох болон хөшөө дурсгал, түүх, соёл, архитектурын дурсгалт барилга байгууламжийг сэргээн засварлахаар гүйцэтгэсэн барилгын ажилд зураг төсөл зохиогчоос хяналт тавих үйл ажиллагаанд энэ дүрмийг мөрдөнө.” гэж заасан нь орон нутгийн түвшинд захиалагч, зохиогчийн хяналтын тогтолцоо бүрдсэн боловч зарим ажилд захиалагч, зохиогчийн хяналт хэрэгжээгүй байна.

Босоо тэнхлэг ба шинэ хотхоны авто зам /Дорнод, Хэрлэн сум/, 2,000.0 сая төгрөгийн ажлын санхүүжилтийн эрхийг ЗТХЯ-наас шууд олгодог учраас захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч “Танил санаа” ХХК, зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэгч “ХЗТ автозам” ХХК-ийн хяналтыг баталгаажуулж, үр дүнг тооцсон эсэхийг тодорхойлох боломжгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2019 онд баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 9.11 дэх “Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хувьд эрх шилжүүлсэн тухай шийдвэр нь тухайн захиалагчийн холбогдох дансанд санхүүжилтийн эрхийг нээх үндэслэл болно.” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

“УЦУОШТ-ийн конторын барилгын дээврийн засвар /Дорнод/, 10.0 сая төгрөг, “УЦУОШТ-ийн конторын барилгын дээврийн засвар /Дорнод, Баян-Уул/, 10.0 сая төгрөгийн ажлуудад зохиогчийн болон мэргэжлийн байгууллагын захиалагчийн хяналт хэрэгжээгүй байна. Захиалагч байгууллагын өгсөн тайлбараар зураг, төсөвт захиалагч, зохиогчийн хяналтын зардал тусгагдсан боловч төсөвт өртөг бага үндэслэлээр захиалагч, зохиогчтой гэрээ байгуулаагүй байна.

Улсын төсвөөс 2021 онд эрх шилжсэн “Цэцэрлэгийн барилгын худгийн насос, шугам сүлжээний засвар /Дорнод, Хэрлэн сум, 12 дугаар цэцэрлэг/-ын ажилд захиалагчийн хяналтын гэрээг ГХБХБГ-тай байгуулж, үр дүнг тооцон 1.1 сая төгрөгийг, зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн “ДОЗТ” ХХК-ийн тайланг үндэслэн 0.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Б.3.2. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь олгосон байна.

Аймгийн ЗДТГ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д зааснаар төсөл, арга хэмжээ бүрээр захиалагчийн хянаж, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлийг үндэслэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг олгох ёстой.

Шинээр эрх шилжиж ирсэн болон он дамжсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг дээрх журмын дагуу захиалагчийн хянаж баталгаажуулсан ажлын гүйцэтгэлийг үндэслэн олгосон байна.

Б.3.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх нь шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд ТЕЗ-ийн дотоод аудит хийгдсэн байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар эрх нь шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тухайн оны

нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 12 дугаар сард дотоод аудитыг хийсэн байна.

Б.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт тухайн жилд батлагдсан санхүүжилтийг бүрэн ашиглах зорилгоор Засгийн газраас гарсан шийдвэрийн хэрэгжилт үр дүнтэй байна.

Б.4.1. Аймгийн Засаг даргын барьцаа хөрөнгийн данснаас 2021 онд санхүүжилт олгогдоогүй байна.

Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4¹⁹, 41 дүгээр зүйлийн 41.2.6²⁰, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6²¹-д төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх болон гүйцэтгэлийн баталгаа, барьцаа хөрөнгийн талаар зохицуулсан байна.

Аймгийн Засаг даргын барьцаа хөрөнгийн дансанд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 1,641.5 сая төгрөг байршсан байгаагаас дараах төсөл, арга хэмжээтэй холбоотой байна. Үүнд:

1. Булган суманд 2020-2021 онд 1,617.8 сая төгрөгийн төсөвт өртгөөр баригдах Соёлын төвийн барилгын ажлыг гүйцэтгэгч “Талын сувд” ХХК шалгарч гүйцэтгэх байсан боловч цар тахлын улмаас барилгын материалын үнийн өсөлт, хомсдолтой холбогдуулан тус ажлаас татгалзаж, 2021 онд тендерийг дахин зарлаж, “ЦОДММ” ХХК шалгарсан байна. Өнгөрсөн 2021 оны 10 дугаар сарын сүүлээр ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан боловч хүйтний улирал эхэлсэнтэй холбогдуулан ажил гүйцэтгээгүй байна. Зураг, төсвийн үнийг хассан дүнгээр буюу 1,344.5 сая төгрөгийг,

2. Хэрлэн суманд 2011-2022 онд хэрэгжиж байгаа 9,130.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Аймгийн ЗДТГ-ын барилга”-ын ажлыг “Ган хийц” ХХК гүйцэтгэж, 2021 онд гүйцэтгэл гараагүйтэй холбогдуулан төсвийн тухай хуульд батлагдсан дүнгээр буюу 50.0 сая төгрөгийг,

3. Халхгол суманд 2021 онд 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр хийгдсэн “Сумын төвийн нийтийн эзэмшлийн шугамыг инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбох” ажлын гэрээний 9-д зааснаар бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний санхүүжилт болох 49.4 сая төгрөгийг аймгийн Засаг даргын барьцаа хөрөнгийн дансанд байршуулж, зарцуулаагүй байна.

Б.4.2. Өмнөх онуудад Засаг даргын барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хөрөнгийг төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын барьцаа хөрөнгийн дансанд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 1,641.5 сая төгрөг байршсан байгаагаас дараах төсөл, арга хэмжээтэй холбоотой байна. Үүнд:

1. Баяндун суманд 2019-2020 онд хэрэгжих 2,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Улз голын урсцыг нэмэгдүүлэх “Онон-Улз” төсөлд 2019 онд 1,100.0 сая төгрөг батлагдаж, 221.0 сая төгрөгийг зураг төсөлд зарцуулан үлдэгдэл 879.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна. Үүнээс “Вэлмот” ХХК-ийн 2020 оны гүйцэтгэлд үндэслэн 681.4 сая төгрөгийг

¹⁹ 24.4. Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.

²⁰ 42.2.6. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх;

²¹ 43.6. Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг захиалагч тендерийн баримт бичигт тусгаж болно.

санхүүжүүлэн төсөл, арга хэмжээ зогссонтой холбогдуулан үлдэгдэл 197.6 сая төгрөг барьцаа хөрөнгийн дансанд байршсан хэвээр байна.

2. Баяндун суманд 2019-2020 онд хэрэгжсэн 1,300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Дотуур байрны барилга /Дорнод, Баяндун сум/”-ын ажлыг “Ди Би Ти Би” ХХК гүйцэтгэж, 2020 онд үүрэг даалгаврын хэрэгжилтээр барилгын ажлыг хүлээлгэн өгч, гадна талбайн тохижилтын ажлын төсөв 57.1 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулан 2021 онд гүйцэтгэлээр нь санхүүжүүлсэн байна.

Б.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцох боломжгүй байна.

Б.5.1. Ашиглалтад орсон 3 барилга, байгууламжийн хувьд 2 нь зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаараа ажиллаж, 1 төсөл, арга хэмжээний хувьд төсөл хэрэгжих хугацаа болоогүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт хэрэгжсэн төсөл, арга хэмжээг НББ-ийн тухай хуулийн дагуу байгууллагын санхүүгийн тайланд бүрэн тусгасан байна.

Хүснэгт 10. “Улсын төсвөөр орон нутагт хэрэгжсэн барилга байгууламжийн ашиглалт, данс бүртгэл”

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч	Ажлын гүйцэтгэл	Бүрэн хүчин чадлаар нь зориулалтын дагуу ашиглалт	Данс бүртгэлд тусгасан эсэх
1	Сумын төвийн нийтийн эзэмшлийн шугамыг инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбох /Дорнод, Халхгол сум/	Ган-Октаэдр ХХК	100 хувь	Тайлант онд төлөвлөгдсөн ажлын гүйцэтгэл 100 хувь хийгдсэн боловч зориулалтын дагуу ашиглагдах хугацаа болоогүй, үе шаттай хэрэгжих төсөл, арга хэмжээ байна.	ОНӨААТҮГ-таа санхүүгийн бүртгэлд тусгасан байна.
2	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 100 ор /Дорнод, Хэрлэн сум/	Сүхжин ХХК	100 хувь	2022 оны байдлаар 1 анги дүүргэлт 25-30, нийт 228 хүүхэдтэйгээр, өргөтгөлийн байрыг бүрэн ашиглаж СӨБ-ын стандартын дагуу орчинд сургалтын үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байна.	12 дугаар цэцэрлэгийн санхүүгийн бүртгэлд тусгасан байна.
3	Соёлын төвийн барилга, 250 суудал /Дорнод, Баян-Уул сум/	Дорнын оч ХХК	100 хувь	2022 оны байдлаар төвийн халаалттай 250 хүний суудалтай нийт сургуулийн сурагчдын хувьд номын санг бүрэн ашиглаж, уншлагын танхимтай болсноор өмнө нь жилд 400 гаран хүнд үйлчилдэг байсан бол одоо 1 сард дунджаар 400 хүнд үйлчилж, соёл хүмүүжлийн ажил сумын хэмжээнд ихээр нэмэгдсэн байна.	Баян-Уул сумын соёлын төвийн барилгыг Соёлын төвийн санхүүгийн бүртгэл тайланд тусгасан байна.

Эх сурвалж: Судлаач

Улсын төсвөөс 2021 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээг данс бүртгэлд бүрэн бүртгэж авсан байна.

Б.5.2. Орон нутагт 2021 онд болон он дамжин хэрэгжиж байгаа төсөвт өртөг үндэслэлгүйгээр нэмэгдсэн төсөл, арга хэмжээ байхгүй байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжсэн 4 төсөл, арга хэмжээ нь төсөвт өртөг нэмэгдээгүй буюу тус онд бүрэн хийгдэж дууссан байна. Харин он дамжин хэрэгжиж буй 7 төсөл арга хэмжээний хувьд төсөвт өртөг өөрчлөгдөөгүй 3 төсөл, арга хэмжээ байна.

Төсөвт өртөг өөрчлөгдсөн төсөл, арга хэмжээний хувьд Баянтүмэн сумын цэцэрлэгийн 150 ортой барилга, Баян-Уул сумын соёлын төвийн 250 суудалтай барилгуудын хувьд жишиг зургаар хийгдэж, зураг, төсөвт инженерийн байгууламж, шугам сүлжээний ажлууд тусгагдаагүй байсантай холбоотойгоор захиалагчдын саналыг Сангийн яаманд удаа дараа хүсэлт хүргүүлснээр улсын төсөвт тусгагдаж батлагдсан байна.

Хүснэгт 11. “Он дамжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн өөрчлөлт /сая.төг/”

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Гэрээ байгуулсан үнийн дүн	Гэрээний үнийн дүнд оруулсан нэмэлт өөрчлөлт
<i>Шилжих</i>				
1	Мэргэжлийн хяналтын газрын лабораторийн болон конторын барилга /Дорнод, Чойбалсан сум/	2,580.7	2,439.0	Өөрчлөлт ороогүй
2	Аймгийн Засаг даргын Тамгын газрын барилга /Дорнод, Чойбалсан сум/	6,194.1	3,198.5 /2011 оны анхны гэрээ/	9,130.4
3	Сумын төвийн нийтийн эзэмшлийн шугамыг инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбох /Дорнод, Халхгол сум/	1,000.0	987.7	Өөрчлөлт ороогүй
4	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Баянтүмэн сум/	1,731.9	1,236.9	1,668.8
5	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 100 ор /Дорнод, Хэрлэн сум/	1,373.0	1,135.6	1,370.5
6	Соёлын төвийн барилга, 200 суудал /Дорнод, Булган сум/	1,617.8	1,617.0	Өөрчлөлт ороогүй
7	Соёлын төвийн барилга, 250 суудал /Дорнод, Баян-Уул сум/	1,797.0	1,252.6	1,772.2

Эх сурвалж: Аймгийн ГХБХБГ-ын аудитын явцад ирүүлсэн судалгаа, 2022 он

Аймгийн ЗДТГ-ын барилгын хувьд анх 2011 онд гэрээ байгуулагдаж байсан ба гүйцэтгэлийн явцад гэрээнд 2014, 2016-2018 онуудад 4 удаа санхүүжилт дутуугаас, ЗТБХБС-ын 2012 оны 181 дүгээр тушаалын хоёр дугаар хавсралт “Барилгын төсөв зохиох дүрэм”, БХБС-ын 2020 оны 30 дугаар “Барилгын төсөв зохиох дүрэм шинэчлэн батлах тухай” тушаалд үндэслэн тус тус 2015, 2021 онуудад 2 удаа төсөвт өртөгт өөрчлөлт оруулснаар гэрээний хугацааг нийт 6 удаа сунгаж, нэмэлт өөрчлөлт оруулж, 2021 оны байдлаар ажлын гүйцэтгэл 85.0 хувьтай, ажил эхэлснээс хойших гүйцэтгэл 5,891.7 сая төгрөгөөр хийгдсэн байна. 2022 онд уг төсөл, арга хэмжээг бүрэн ашиглалтад оруулахаар гэрээнд тусгасан байна.

Анхны төсөвт өртгийг тооцож төсөвт тусгахдаа гадна инженерийн байгууламж, шугам сүлжээний ажлыг тооцож тусгаагүй зарлагдсан 2 төсөл, арга хэмжээ байна.

Б.5.3. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Өмнөх онд хийсэн аудитаар аймгийн Засаг даргад зөрчлийг арилгуулахаар өгсөн 5 албан шаардлага, 3 зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэхийг аймгийн Засаг даргын Тамгын газраас 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 6/2185 тоот албан бичгээр ирүүлсэн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт болон аудитын мөрөөр хяналт тавьж үзэхэд албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн гэж үзэж байна.

Б.5.4. Улсын төсвийн санхүүжилтээр 2021 онд эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээнд хөрөнгө оруулалт хийгдээгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд орон нутагт хийгдсэн төсөл, арга хэмжээнүүдийн хувьд хөрөнгө оруулалтын үр дүнг захиалагчдаас авсан саналаар гүйцэтгэлийг дүгнэхэд хангалттай байна.

Гэхдээ 2021 оны хувьд Улсын төсвийн санхүүжилтээр орон нутагт эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээнд хөрөнгө оруулалт хийгдсэн гэж үзэх боломжгүй байна.

Хүснэгт 12. “Төсөл, арга хэмжээнээс бий болсон үр дүн, өгөөж”

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хөрөнгө оруулалт хийгдсэнээр бий болсон үр дүн, тайлбар
Шилжих		
1	Сумын төвийн нийтийн эзэмшлийн шугамыг инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбох /Дорнод, Халхгол сум ²² /	Монгол орны хамгийн зүүн урд хэсэг буюу алслагдсан иргэдийн нийгмийн байдал, амьдрах нөхцөлийг сайжруулах, тав тухтай, хотжилтын хөгжлийн суурь болсон байна. Ингэснээр Дорнод аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилт 5.4 ²³ -д тусгагдсан аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж нэмэгдэж байна.
2	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 100 ор /Дорнод, Хэрлэн сум/	СӨБ-ийн стандартад нийцсэн анги танхим, анги дүүргэлтийн хэвийн түвшин, нэг хүүхдэд зарцуулах багшийн цаг нэмэгдсэнээр сургалтын чанар дээшилсэн байна. Мөн хамран сургах тойрогт багтсан Хэрлэн сумын 9 дүгээр багын хүүхдүүдийн тус цэцэрлэгт хамрагдах боломж нэмэгдсэн байна. Ингэснээр аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилт 3.1.1 ²⁴ -т тусгагдсан боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх боломж дээшилж байна.
3	Соёлын төвийн барилга, 250 суудал /Дорнод, Баян-Уул сум/	Орон нутагт ажиллах соёлын байгууллагын албан хаагчдын ая тухтай зориулалтын ажлын байранд ажиллах нөхцөл бололцоог бий болгож сэтгэл ханамжтай, тогтвортой ажиллахад суурь нөхцөлийг бүрдүүлсэн байна. Мөн орон нутгийн хувьд иргэдийн соёл хүмүүжлийн хөгжлийг мэдэгдэхүйцээр нэмэгдүүлсэн байна. Ингэснээр аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилт 2.1 ²⁵ -т тусгагдсан соёл урлагийн үйлчилгээг алслагдсан орон нутгийн иргэдэд дэлгэрүүлж байна.
Шинэ		
1	Цэцэрлэгийн барилгын худгийн насос, шугам сүлжээний засвар /Дорнод, Хэрлэн сум, 12 дугаар цэцэрлэг/	Ажиллах нөхцөл болон барилга ашиглалтын хугацааг нэмэгдүүлж байна.
2	УЦУОШТ-ийн конторын барилгын дээврийн засвар /Дорнод, Хэрлэн сум/	
3	УЦУОШТ-ийн конторын барилгын дээврийн засвар /Дорнод, Баян-Уул/	

Эх сурвалж: Аудиторын судалгаа

Орон нутагт 2021 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжихтэй холбоотой бүтээн байгуулалтын ТАХ-д нь хэрэгжих хугацаа болоогүй байна. Харин тайлант онд УТХО-аар хийгдсэн ТАХ-нүүд нь их засварын ажлууд байна.

Б.5.5. Хэрэгжиж дуусан төсөл, арга хэмжээний үр дүнд дэд бүтцийн салбарын хүчин чадал нэмэгдээгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд 1 соёлын төв, 1 цэцэрлэгийн өргөтгөл, 1 инженерийн шугам сүлжээ, 3 барилгын засварын ажил, нийт 6 төсөл, арга хэмжээ хэрэгжиж дууссан бөгөөд тухайн байгууллагуудын ашиглалтын хүчин чадал нэмэгдэж байгаа боловч, орон нутгийн дэд бүтцийн салбарт хүчин чадал нэмсэн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Босоо тэнхлэг ба шинэ хотхоны авто зам, Сумын төвийн нийтийн эзэмшлийн шугамыг инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлууд хэрэгжиж дууссанаар дэд бүтцийн салбарт хүчин чадал нэмэгдэхээр байна.

²² Дорнод аймгийн Халхгол сум 320 гаруй жилийн түүхтэй, Монголын түүхэнд бичигдсэн түүхэн дурсгалт газрууд ихтэй нутаг юм.

²³ Аймгийнхаа байгалийн болон түүх, соёлын нөөцөд тулгуурлан байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, хүлээн авах жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

²⁴ Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 2020 онд 87.3 хувь байсныг 2025 онд 90.0 хувьд, ЕБС-ын бага боловсролын хамран сургалт 97.9 байсныг 98.4 хувьд, суурь боловсролын хамран сургалт 93.5 хувь байсныг 98.0 хувьд тус тус хүргэнэ.

²⁵ Үндэсний өв соёлыг өвлүүлэн хөгжүүлэх, соёлын үнэт зүйлсийг бий болгож, соёл урлагийн үйлчилгээг өргөжүүлнэ.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

21000, Чойбалсан, Дорнод аймаг
Утас: 7058-4202, факс: 7058-4584

2022.04.27 № 1/930
танай _____-ны № _____-т

Г ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.БОЛОРТУУЛ ТАНАА 7

“Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-нд хийсэн аудитын тайлангаар ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ Ч.ТАНБАТ

010622344

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

А.1.1. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нь орон нутгийн бодлогын баримт бичигт нийцсэн байна.

А.1.2. Жагсаалтад батлагдсан 2021 оны төсөл, арга хэмжээ нь дээд шатны байгууллагын болон УИХ-ын гишүүдийн санаачилгаар батлагдсан учир орон нутгийн салбарын бодлого, ТЕЗ-ын саналд үндэслээгүй байна.

А.1.3. Орон нутгийн хэрэгцээ шаардлага, санал хүсэлтийн дагуу эрэмбэлсэн төсөл, арга хэмжээ нь улсын төсөвт тусгагдаагүй байна.

А.2.1 Өмнөх оноос шилжиж ирсэн ТАХ-нд барилга, байгууламжийн зураг, төслийн ажлын даалгаврыг хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэн боловсруулаагүй, төсөв зургийн дагуу батлагдаагүй зөрчлүүд байна.

А.2.2 Барилга, байгууламж, засварын ажлын зураг төслийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүд боловсруулж, баталгаажуулсан байна.

А.2.3. Барилгын засварын ажлын зураг төсөвт олгосон зардлыг бодит гүйцэтгэл, жишиг үнэд үндэслэсэн байна.

А.2.4. Өмнөх оноос шилжиж ирсэн аймгийн Засаг даргын Тамгын газрын барилгын төсөвт 4 удаа өөрчлөлт орсон байна.

А.2.5. Магадлалын ерөнхий дүгнэлтээр шинээр хэрэгжих 1 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдсэн байна.

А.3.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нь ТЕЗ-ын хөрөнгө оруулалтын эрэмбэлсэн жагсаалтад багтаагүй учир хэрэгцээ шаардлагыг үнэлэх боломжгүй байна.

А.3.2. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангаж ажиллаагүй байна.

А.3.3. Төсөл арга, хэмжээний санхүүжилт нь хэрэгжих боломжтой байдлаар батлагдсан байна.

А.3.4. Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөж батлаагүй байна.

Б.1.1. Хөрөнгө оруулалтын 2,064.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ-ний эрхийг холбогдох журамд заасан хугацаанаас хоцроож шилжүүлсэн байна.

Б.1.2. Төсөл, арга хэмжээг тайлант онд хэрэгжих боломжтой хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Б.1.3. Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулж, батлуулсан байна.

Б.1.4. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй байдлаар сонгон шалгаруулсан байна.

Б.1.5. ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны тайланг Шилэн дансны хууль журамд заасны дагуу цахим хуудаст ил тод мэдээлээгүй байна.

Б.2.1. Гүйцэтгэгчид төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд дуусгаагүй, дутуу гүйцэтгэсэн зөрчлүүд илэрч байна.

Б.2.2. Шинээр хэрэгжсэн барилгын засварын ажилд зохиогч, мэргэжлийн байгууллагын хяналт хэрэгжээгүй байна.

Б.2.3. Хөрөнгө оруулалтаар техник, тоног төхөөрөмж бэлтгээгүй байна.

Б.2.4. Өмнөх онуудаас хэрэгжиж дуусаагүй орхигдсон 4,270.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга, байгууламж байна.

Б.2.5. Хөрөнгө оруулалтаар орон нутагт хийж гүйцэтгэсэн зураг, төслийг холбогдох хууль, барилгын норм, дүрэм, стандартын дагуу боловсруулж, 2021 онд холбогдох төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд ашигласан байна.

Б.3.1. Хяналтын тогтолцоо бүрдсэн боловч 2 барилгын засварын ажилд мэргэжлийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагатай гэрээ байгуулаагүй, үр дүнг тооцоогүй байна.

Б.3.2. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь олгосон байна.

Б.3.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх нь шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд ТЕЗ-ийн дотоод аудит хийгдсэн байна.

Б.4.1. Аймгийн Засаг даргын барьцаа хөрөнгийн данснаас 2021 онд санхүүжилт олгогдоогүй байна.

Б.4.2. Өмнөх онуудад Засаг даргын барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хөрөнгийг төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлсэн байна.

Б.5.1. Ашиглалтад орсон 3 барилга, байгууламжийн хувьд 2 нь зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаараа ажиллаж, 1 төсөл, арга хэмжээний хувьд төсөл хэрэгжих хугацаа болоогүй байна.

Б.5.2. Орон нутагт 2021 онд болон он дамжин хэрэгжиж байгаа төсөвт өртөг үндэслэлгүйгээр нэмэгдсэн төсөл, арга хэмжээ байхгүй байна.

Б.5.3. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Б.5.4. Улсын төсвийн санхүүжилтээр 2021 онд эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээнд хөрөнгө оруулалт хийгдээгүй байна.

Б.5.5. Хэрэгжиж дуусан төсөл, арга хэмжээний үр дүнд дэд бүтцийн салбарын хүчин чадал нэмэгдээгүй байна.

Аудитаар нийт 4 зөвлөмж өгч, нэгтгэсэн тайланд тусгуулах 6 саналыг Үндэсний аудитын газарт хүргүүллээ.

САНАЛ:

Үндэсний аудитын газарт:

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлэх талаар холбогдох газарт уламжлах. Үүнд:

А.1.2. А.1.3. УТХО-д тусгуулахаар ТЕЗ буюу Засаг даргад хүргүүлсэн саналд үндэслэхгүй хөрөнгө оруулалтыг төлөвлөн баталж байгааг авч үзэх.

А.3.2. Салбарын яамдын сайдын хөрөнгө оруулалтын багцад багтсан хөрөнгө оруулалтыг тухайн орон нутгийн ТЕЗ-ын хөрөнгө оруулалтын жагсаалтад эрэмбэлсэн эсэхийг тулган баталгаажуулж улсын төсөвт тусгах.

Б.1.1. Орон нутагт төсөл, арга хэмжээний эрхийг тухайн оны 1 дүгээр улиралд багтаан шилжүүлэх талаар талаар холбогдох журамд санал тусгуулахаар уламжлах.

Б.3.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлэхдээ санхүүжилтийг эрхийг хамт нээж, Сангийн сайдын 2019 оны 418-р тушаалын 9.11 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар холбогдох ЗТХЯ-нд уламжлах.

Б.2.4. “Улз голын урсцыг нэмэгдүүлэх “Онон-Улз” төсөл, арга хэмжээ зогссонтой холбогдуулан холбогдох яаманд /БОАЖЯ/ тус байгууламжийг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжтой эсэхэд дүгнэлт гаргуулж, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх талаар уламжилж шийдвэрлүүлэх.

Б.5.4. Тухайн төсвийн жилд эдийн засгийн өсөлт, ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн ТАХ-г хэрэгжиж дуусаж байхаар тооцон ТЕЗ-чид хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгаж байх талаар холбогдох газарт уламжлах.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд:

Б.2.1. “Баян-Уул сумын соёлын төвийн барилга”-ын ашиглалтын явцад үүссэн зөрчил дутагдлыг гүйцэтгэгч байгууллагаар баталгаат хугацаанд засварлуулах.

Б.2.4. Хэрлэн сумын 6-р багт хэрэгжиж байгаад зогссон /царцаагдсан/ “Спорт цогцолборын өргөтгөл, усан бассейн”-ны газар, объектыг дуудлага худалдаанд оруулах, эсвэл төсвийн алдагдлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үр дүнтэй арга хэмжээг авч ажиллах. /1,770.0 сая төгрөгөөс 384.0 сая төгрөгийг олгосон./

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга Г.Гарамхишигт:

Б.2.1. Барилгын засварын ажлын гүйцэтгэлийг гэрээний баталгаат хугацаанд дуусгуулж, төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр ашгийг нэмэгдүүлэх.

Б.2.2. Б.3.1. Цаашид эрх шилжиж ирсэн ТАХ-ний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай /зохиогч болон ГХБХБГ/ гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж, хяналтыг сайжруулан үр дүнг тооцож байх.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 05-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 9

Чойбалсан хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын гуравдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга М.Энхтөр, аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн нарт тус тус хүргүүлсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Я.Зоригт даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

011010013

Дорнод аймаг Хэрлэн сум, 7-р баг, аймгийн Засаг даргын
Тамгын газрын 2-р байр, 1, 2 давхарт
Утас: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-мэйл: dornod@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn